



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 11592

Арвайхээр

### Г Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 2.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч их хэмжээгээр тархсан Баянгол, Зүүнбаян-Улаан, Тарагт, Нарийнтээл, Өлзийт, Хужирт сумдын 40.0 мянган га бэлчээрт энгийн механик биологийн аргаар мэрэгчтэй тэмцэх ажлыг 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.
2. Сумдын бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх талбайн хэмжээ, зардлын хэмжээг хавсралтаар баталсугай.
3. Мэрэгч амьтантай тэмцэх ажилд иргэд, малчид, малчдын бүлэг хоршоог хамруулж тэднийг мэрэгч устгалын гарын авлага, шаардлагатай техник хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах болон цаг агаарын saatlaas бусад тохиолдолд ажил saataghuy байх бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээг авч, хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.
4. Энэхүү ажлын явц, үр дүнг тооцож, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), уг ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101087

Аймгийн Засаг даргын 2019 оны 09  
дугаар сарын 26-ны өдрийн 10:00 дугаар  
захирамжийн хавсралт

**СҮМДЫН БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ МЭРЭГЧ АМЬТАНТАЙ  
ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ**

д/д	Сум, байгууллагын нэр	Мэргчтэй тэмцэх талбайн хэмжээ /мянган га/	Зарцуулах хөрөнгө /мянган төгрөг/	Зарцуулах зориулалт
1	Баянгол	6.0	13500.0	Оготно устгалд оролцсон хүмүүс, авто машины шатахууны зардал
2	Зүүнбаян-Улаан	6.0	13500.0	Оготно устгалд оролцсон хүмүүс, авто машины шатахууны зардал
3	Тарагт	6.0	13500.0	Оготно устгалд оролцсон хүмүүс, авто машины шатахууны зардал
4	Нарийнтээл	8.0	18000.0	Оготно устгалд оролцсон хүмүүс, авто машины шатахууны зардал
5	Өлзийт	6.0	13500.0	Оготно устгалд оролцсон хүмүүс, авто машины шатахууны зардал
6	Хужирт	8.0	18000.0	Оготно устгалд оролцсон хүмүүс, авто машины шатахууны зардал
7	Хүнс, хөдөө аж ахуйн газар		10000.0	Хяналт, томилолт, хөдөлмөр хамгаалал, бичиг хэрэг, бусад зардал
Дүн		40.0	100000.0	